

Их Эзэний арга замаар бие даах чадвараа хөгжүүлэх

Доорх судрын эшлэл, тайлбаруудыг судлаад, дараах хоёр асуултын хариултыг ол.

1. Их Эзэн судрууд болон бошиглогчдоороо дамжуулан бие даах чадвараа хөгжүүлэхэд туслах юуг бидэнд заасан бэ?
2. Тэнгэрлэг Эцэгээс тусламж авахад ямар саад бэрхшээл хүнд тулгарч болох вэ?

Сургаал ба Гэрээ 9:7–8

Сургаал ба Гэрээ 58:26–28

Сургаал ба Гэрээ 88:124

Иосеф Смит—Түүх 1:55

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994) ийн заасан.



Их Эзэн дотроос гадагш чиглэж ажилладаг. Дэлхийн хандлага гаднаас дотогшоо чиглэдэг. Дэлхий хүмүүсийг ядуурлаас гаргадаг. Христ эхлээд ядуурлыг хүмүүсийн дотроос гаргаж, үүний дараа тэд өөрсдийгөө ядуурлаас гаргадаг. Дэлхий хүмүүсийн орчныг өөрчлөх замаар тэднийг төлөвшүүлдэг. Харин Христ эхлээд хүмүүсийг өөрчилж, дараа нь хүмүүс хүрээлэн буй орчноо өөрчилдөг. Дэлхий хүмүүсийн зан байдалд нөлөөлж болох ч Христ хүмүүсийн мөн чанарыг өөрчилдөг. (Ezra Taft Benson, "Born of God," *Ensign*, Nov. 1985, 6)

Тэргүүн зөвлөлийн ерөнхийлөгч асан Дийтр Ф.Угдорф ийн тайлбарласан.



Гол гатлахгүйн тулд голын усыг дуусахыг хүлээн суух . . . нь Их Эзэний арга зам биш ээ. Нэгдэн нийлж, ханцуйгаа шамлан хөдөлмөрлөж, гүүр юм уу завь бүтээж өөрсдийн бэрхшээлийн голыг гатлах нь Их Эзэний арга зам мөн. (Дийтр Ф.Угдорф, "Их Эзэний замаар хангах нь," 2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 67)